

УБД-ын 1993 оны АЗСЗР захиралдаар хурааруул.



БНМАУ

УЛААНБААЛТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ  
ТОГТООЛ

1998 оны 9  
сарын 15 өдөр

дугаар 234

Улаанбаатар  
хот

Согтуурагчидтай тэмцэх  
арга зүйн төв клуб бай-  
гуулахтай холбогдох за-  
рим арга хэмжээний тухай

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Сүхбаатарын районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны харьяалалд ажиллаж байгаа "Архи үл хэрэглэгчдийн клуб" ийг "Согтуурагчидтай тэмцэх арга зүйн төв клуб" болгон 2 жилийн хугацаагаар туршиж, түүнийг хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны Эрүүлийг хамгаалах газрын харьяанд ажиллуулахаар тогтоосугай.

2. "Согтуурагчидтай тэмцэх арга зүйн төв клубын дүрэм"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

3. Сүхбаатарын районы "Архи үл хэрэглэгчдийн клуб"-ийг төв клуб болгон туршиж ажиллуулах болсонтой холбогдуулан энэ оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн их эмч, сувиллагч, асрагч тус бүр нэгийг урьдын адил хотын Эрүүлийг хамгаалах газрын системийн орон тоо, цалингийн фондод багтаан гаргаж ажиллуулахыг хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны Эрүүлийг хамгаалах газар /н.Бямба/, санхүүгийн хэлтэс /н.Гонгор/-т даалгасугай.

4. Төв клубын зөвлөлийн даргын сарын цалинг 800 төгрөгөөр тогтоосугай.

5. Согтуурагчидтай тэмцэх арга зүйн төв клубын зөвлөлийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Төв клубын зөвлөлийн даргад:

Н.Цэвэгмэд - их эмч

Мөн зөвлөлийн нарийн  
бичгийн даргад:

Б.Дашцэрэн - Хотын цагдаагийн газрын сэр-  
гийлэн хамгаалах ахлах байцаагч

Гишүүдэд:

- Н.Пүрэвдаш - "Хөдөлмөр" сонгоно утга зохиолын нарийн бичгийн дарга
- Л.Батгаль - Хотын ХЗЭ-ийн хорооны ХНШ-ийн нарийн бичгийн дарга
- Ч.Батсүх - Сүхбаатарын район дахь сортуучуудыг эрүүлжүүлэх группийн ажлагч
- Д.Батсуурь - Октябрийн район дахь сортуучуудыг эрүүлжүүлэх группийн ажлагч
- Д.Энхээ - Сурган хүмүүжүүлэх ухааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

6. Тус төв клубын үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага, туслалцаа үзүүлж байхыг хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны Эрүүлийг хамгаалах газар /н.Бямбаа/, Хуулийн хэлтэс /н.Далайхамуу/, Ариун цэвэр хялбар судлалын станц /н.Батчулуун/-д даалгасугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дор дурдсан тогтоолыг хүчингүй болгонд тооцсугай.

а/ "Архи ул харэглэгчдийн клуб байгуулах тухай" 1986 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 216 дугаар тогтоол.

б/ "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 1986 оны 12 дугаар сарын 23-ны 261 дүгээр тогтоол.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЭЛГЭДЭГЭД  
 ХУУЛЬН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ  
 ДАРГА *[Signature]* С.НЭХУМАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ  
 ЗАХИРГААНЫ БАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН  
 БИЧГИЙН ДАРГА *[Signature]* Д.АЛТИА



Гүйцэтгэх Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны  
захиргаа 1988 оны 234 дугаар тогтоолоор  
батлав.

**УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ  
ЭРҮҮЛЭГТ ХАМГААМАХ ТАСРЫН ДЭГТЭГЭХ СОГТУУРАГ-  
ЧИДТАЙ ТЭМЦЭХ АРГА ЗҮЙН ТӨВ КЛУБЫН ДҮГЭМ**

**НЭГ. Клубын нийтлэг үндэснэл, байгууллагдах журам**

1. Сogтуурагчидтай тэмцэх арга зүйн төв клуб нь /цаашид төв клуб гэх нэрлэнэ/ архидан согтуурах явдалтай тэмцэх талаар хөдөл-мөрсдийн идэвх хөдөлгөөнийг орнуулан согтууруулах үндэвэг үл хэ-рэглэх асуудлыг нийтийн хэвшил болгох чиглэлээр үүсч байгуулаг-даж байгаа бусад клуб, хамтлагруудад болон иргэдэд туслалцаа үзүүлэх зорилго бүхий олон нийтийн арга зүйн байгууллага мөн.

2. Төв клубын зорилт нь архид эрхичдэг эмчлэх байгууллага болох наркологийн кабинет, төвүүдийн хяналтад үл хамаарах архичин хүмүүсийг эмийн бус эмчилгээ-сүртэлчилгээний өвөрмөц аргаар архи-наас гаргах ба архи цээрлэгч, үл хэрэгсэлчдийн салбар клуб, хамт-лагийг мэргэжлийн талаас удирдах, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр ажиллан, архидан согтуурах явдалыг нийтээр жигших уур амьсгал бий болгох, согтууралтай тэмцэх талаар явуулах сүй нам, засгийн тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэхэд оршино.

3. Төв клубын үйл ажиллагааг өдөр тутам эрхлэн явуулахын тулд 7 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөл ажиллана.

4. Клубын зөвлөл эмнэлэг-сэтгэл засмал, хууль зүйн гэсэн хоёр сектортой байх бөгөөд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, 5 гишүүнтэй байна. Клубын бүрэлдэхүүнд анагаах ухаан, хууль зүй, сур-ган хүмүүжүүлэх ухааны болон сэтгэл зүйч зэрэг мэргэжлийн хүмүү-сийг оруулна.

5. Эмнэлэг-сэтгэл засмалын секторын эрхлэгч нь төв клубын зөв-лөлийн дарга, хууль зүйн секторын эрхлэгч нь төв клубын зөвлөлийн нарийн бичгийн дарга байна.

6. Төв клуб нь үйл ажиллагаандаа БН АУ-ын хууль тогтоомж, хо-тын АДХ-ын гүйцэтгэх захиргааны шийдвэр, энэ дүрмийг удирдлага болгон хууль, сурган сэтгэл зүй болон анагаах ухааны ололтыг ашиг-лана.

7. Төв клубийг хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны шийдвэрээр бай-гуулж төв клубын зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг батал-на.

ХОЁР.Тов клубын зөвлөлийн үүрэг.

8.Архаг архицдыг эмчлэх наркологийн кабинет, төвүүдийн эмчилгээ, хяналтад үл хамаарах архичин хүмүүсийг архинаас гаргах талаар эрх хэмжээндээ тохирсон асуудлаар дэс дарамсан арга хэмжээ авна.

9.Өөрийн хяналтад хамаарах архицдыг суртгал, судалгааг район, хороод, үйлдвэр, албан газруудаас гаргуулан авч, тэдгээрийг судалж танилцан архинаас гаргах ажил зохино.

10.Тусгай программаар архины хор холбогдол, түүнээс гарах зайлшгүй эхй тогтлын талаар хичээл сургалт, сурталчилгаа явуулна.

11.Нийслэл хотын хэмжээнд ажиллаж байгаа архи цээрлэгч, үл хэрэглэгчдийн клубууд, хамтлагийн ажлыг танилцах, нэлгэх, сөмнарлах зэргээр мэргэжлийн удирдлагаар хангах, ажилд нь арга эхйн дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

12.Архицан согтуурч байгаа шалтгаан нөхцөлийг судлан илрүүлж, тэдгээрийг арилгах тамаар асуудал боловсруулах хот,районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа, хуулийн байгууллагад оруулна.

13.Архицан согтууралчгүй хамт олон болох хөдөлгөөнийг өрнүүлэн зохион байгуулах, хотын хэмжээнд нэгтгэн дүгнэж ажиллана.

ГУРАВ.Тов клубын зөвлөлийн эрх.

14.Өөрийн клубын хяналтад хамаарагдах архицдын судалгааг район, хороод, үйлдвэр албан газраас гаргуулах, архицдыг судлах, согтууралтай тэмцэх асуудалтай холбогдсон мэдээ, судалгаа,бичиг баримт каарман авах, энэ талаар дүгнэлт гаргах;

15.Архицан согтуурах явдалтай тэмцэх талаар албан газар, байгууллага дээр шалгах, танилцах, айл өрхөөр орох, асууж лавлах тодорхойлолт гаргуулах.

16.Архи цээрлэгч, үл хэрэглэгчдийн клуб, хамтлагийн ажлыг нэлгэх, тэдгээрийн сонгуультны сонголт, мэдээллийг зөвлөлийн хурлаар хэлэлцэх, заалт чиглэл, зөвлөж гаргах мөрдүүлэх.

17.Хяналтад авагдсан архицдаас архинаас гарахгүй үргэлжлэн уувал холбогдох районы наркологийн кабинетиин мэдэлд шилжүүлэх,

3.

эмчлүүлэхээс зайлсхийвэл хөдөлмөр эмчилгээний газар явуулахад материалыг бүрдүүлэхийг холбогдох байгууллагад шаардах.

18. Өөрийн клубын хяналтад байсан армичин хүмүүс архи хэрэглэхгүй болсон нь нотлогдвол тодорхой хугацаанд шалтгаад гэрчилгээ болгож, бүртгэл, судалгаанаас хасах.

ДӨРӨВ. Төв клубын зөвлөлийн ажлын зохион байгуулалт

19. Төв клубын зөвлөл нь зөвлөлийн туршиар баталсан жил, улирын төлөвлөгөө, салбар, клуб, хамтлагийг шалгах графикай ажиллана.

20. Төв клубын зөвлөл нь ажлын шаардлагын дагуу хуралдах, протокол хөтөжнө. Зөвлөлийн туршиар салбар клуб, хамтлагийн сонгуультны сонгоол, мэдээлэл, шалгалтын дүн, зарим армичдын асуудал, төлөвлөгөөний биелэлтийн явц, гишүүдийн ажлын байрлыг дүгнэх, хичээл сургалт дүн шийжиглэвэний ажлын өгөөж, зөвлөлийн биелэлт зэрэг асуудал холбоонож олонхийн санаагаар эрх хэмжээнд бэлтгэн асуудлаар зөвлөж гаргаж хэрэгжүүлнэ.

21. Төв клубын зөвлөл нь хуулийн байгууллага, наркологиын төв, кабинетүүд, ардын нөхөрлөл, хэв журам хамгаалах олон нийтийн төв, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн хамт олын зөвлөлтэй нягт холбоотой ажиллах, шаардлагатай бол хамтарсан хурал, зөвлөлдөөн, семинар зохиож байна.

22. Төв клубын зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн ажил, үүргийн хуваарийг боловсруулах, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны эрхийг хамгаалах газар, хуулийн хэлтсийн даргаар батлуулах мөрдөнө.

ТАВ. Төв клубын зөвлөлийн үйл ажиллагаа, удирдлага

23. Төв клубын үйл ажиллагааг хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны Хотын эрхийг хамгаалах газар, хуулийн хэлтэс удирдах, мэргэжлийн дэргэдэг туслахаар үзүүшнэ.

24. Төв клубын зөвлөл нь үйл ажиллагааныхаа тухай тайлангаа хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд жилд нэгээс доошгүй удаа ирүүлнэ.

4.

25.Төв клубын зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг тэдний амьдрал, үр дүн, хотын АЖХ-ын гүйцэтгэх захиргааны хуулийн хэлтэс, эрүүлийг хамгаалах газрын саналыг харгалзан хотын АЖХ-ын гүйцэтгэх захиргаанаас шагнаж урамшуулна.

26.Төв клубын зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс дуралд багасан хургаа хүлээгдэх шалтгаангүйгээр биелүүлээгүй буруу хууль ёс, хөдөлмөрийн сахилга зөрчсөн бол хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу хотын АЖХ-ын гүйцэтгэх захиргаанаас арга хэлтээ авна.